

ИЛ ТОД БАЙДАЛ

Компанийн засаглалын тогтолцоог олон улсын сайн туршлагад нийцүүлэн хөгжүүлж, ил тод, хариуцлагатай засаглалыг төлөвшүүлэхээр тууштай ажиллаж байна.

"Монголын төмөр зам" ТӨХК нь компанийн засаглалын сайн туршлагыг нэвтрүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдлыг хангах, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна.

ТУЗ нь олон талт туршлага бүхий гишүүдээс бүрдэж, компанийн стратеги, бодлогын шийдвэрийг хараат бусаар хэлэлцэн баталдаг.

Төлөөлөн удирдах зөвлөл



БЯМБА-ЮУ АРТУР
ТУЗ-ийн дарга

НОРЖИНЛХАМ МӨНХБАТ
ТУЗ-ийн гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга

ХҮЧИТБААТАР ИТГЭЛТ
ТУЗ-ийн гишүүн

СҮХЭЭ МЯНДАСМАА
ТУЗ-ийн гишүүн

НАЦАГДОРЖ ГАНБОЛД
ТУЗ-ийн гишүүн, Цалин, урамшууллын хорооны дарга

БАТМӨНХ АМАРЬ АЯСГАЛАН
ТУЗ-ийн гишүүн

ДАВААСҮРЭН НАР-ОД
ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга

ЖАМСРАН АРИУНАА
ТУЗ-ийн хараат бус гишүүн

ДАГМИД ЯНЖИНСҮРЭН
ТУЗ-ийн хараат бус гишүүн

"Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компани нь 100 хувь төрийн өмчит компани бөгөөд Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлж ирсэн ба Монгол Улсын Засгийн газрын 2025.03.19-ний өдрийн 137 дугаар тогтоолоор компанийн төрийн эзэмшлийн эрх хэрэгжүүлэгчээр "Эрчист Монгол" ТӨХК-ийг тогтоосон.

Төлөөлөн удирдах зөвлөл:

ТУЗ НИЙТ 9 ГИШҮҮН	ТӨРИЙН ТӨЛӨӨЛӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ 6 ГИШҮҮН	ХАРААТ БУС 3 ГИШҮҮН
--------------------------------	----------------------------------------------------	----------------------------------

2025 ОНД ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- 24 удаа хуралдаж /ээлжит болон ээлжит бус/
- 44 асуудал хэлэлцэж,
- 50 тогтоол шийдвэр гаргаж,
- Үүрэг даалгаврын биелэлт **97.27%** байна.

Гол хэлэлцсэн асуудлууд:

Компанийн стратеги алхмууд, гадаад хамтын ажиллагааны хэлэлцээрүүд, төсөл, хөрөнгө оруулалтын чиглэлийн шийдвэрүүд, компанийн дотоод менежменттэй холбоотой байв.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

- **Аудитын хороо:** 2025 онд нийт 20 удаа хуралдаж, 52 асуудлыг хэлэлцэн 28 дүгнэлт, санал зөвлөмж гаргасан. Аудитын дүгнэлтүүд нь санхүү, дотоод хяналт, тайлагналын ил тод байдал, эрсдлийн менежментэд чиглэсэн байна.
- **Нэр дэвшүүлэх хороо:** 2025 онд 3 удаа хуралдаж холбогдох дүгнэлт, шийдвэр гаргасан, эрх бүхий албан тушаалтныг томилох болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн байна.
- **Цалин, урамшууллын хороо:** 2025 онд 4 удаа хуралдаж холбогдох дүгнэлт, шийдвэр гаргасан, үүнд ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон ажиллагсдын цалин хөлсний журамд хамаарах саналыг хэлэлцсэн.

ДОТООД ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАН АЖИЛЛАВ

Хяналтын алба эрсдэлд суурилсан дотоод хяналтыг хэрэгжүүлж, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, галт тэрэгний хөдөлгөөний тасралтгүй байдлыг хангахад анхаарч ажиллалаа.



Гүйцэтгэх захирлын нэрэмжит үзлэгийг бүх өртөө, нэгжүүдэд зохион байгууллаа.

Шинэжурмын хүрээнд Зүүн баян-Цогтцэций, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлүүдийн бүх өртөө, зөрлөг, анги нэгжүүдэд үзлэг хийж

- ажилтнуудын санал хүсэлтийг сонсож
- зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэж
- мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллав.

Үйл ажиллагааны мэдээллийг цахимжуулах суурь тавигдав.

Шийдвэр гаргалтыг шуурхай болгох зорилгоор:

- "Power BI" систем нэвтрүүлэхээр **20 ажилтныг сургалтад** хамруулсан
- "Smart Logic" ХХК-тай хамтран хүний нөөц болон худалдан авалтын системийг шинэчлэх судалгаа эхлүүлэв.

Дотоод аудитын онцлох ажлууд

- Орлогын бүртгэлийн асуудлыг судалж, тайлагналын чанарыг сайжруулав
- Цогтцэций өртөөний цалин, нэмэгдлийн олголтыг журамтай нийцэж буй эсэжийг шалгав
- Үндэсний аудитын **16 зөвлөмжийн биелэлтийг хангав**
- 2024 оны санхүүгийн тайланд өгсөн **11 зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө** боловсрууллаа
- Шилэн дансны мэдээллийг хариуцах чиг үүргийг шинэчлэн батлуулсан
- Аудитын хорооноос өгсөн **7 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэв.**

Шилэн дансны хэрэгжилт

Холбогдох журмын дагуу нийт **168 мэдээллээс 163-ыг** хугацаанд нь байршуулж, үлдсэн мэдээлэлд хяналт тавин ажиллалаа.

Тээврийн аюулгүй байдлын хяналт

ГОЛОГДЛЫН ТОО

26

49% vs 2024

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтуудыг зохион байгуулж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэв.